



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/03/НА-СТА-ОНА

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn Сүхбаатар сум 2024 он	Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитыг гүйцэтгэсэн: Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн Захирал: О.Бурмаа Утас: 99168735 Цахим хаяг: aetb.audit@gmail.com
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт.....	12
3.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	13
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
5. Аудитын илрүүлэлт.....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ААТҮГ	Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ТБОНОХБАХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар



ӨРГӨН СЭЛЭНГЭ ҮЙЛЧИЛГЭЭ” ААТҮГ-ЫН
ДАРГА И.ЧУЛУУНБОЛД ТАНАА

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.03.15 № СЭА-2024/03-НА-СТА-ОНА
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 12,154.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.1.2, 20.1.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь тайлант онд 1,251,748.3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 1,835,524.3 мянган төгрөгийн зардал гарган, 583,779.5 мянган төгрөгийн алдагдалтай тайлагнагдсан байна.

Аудитын гол асуудал

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны нийт зардлын төлөвлөгөөнд үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг тооцож төлөвлөөгүйгээс гүйцэтгэлээр 1,835,524.3 мянган төгрөгөөр тайлагнагдаж, зардлын төлөвлөгөөг 758,083.8 мянган төгрөгөөр буюу 70.4 хувиар хэтрүүлсэн байдалтай байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	6,711,541.52	34,465,861.56
1.1.2	Дансны авлага	88,617,967.50	118,335,342.50
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	280,256,956.29	449,898,361.50
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	375,586,465.31	602,699,565.56
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	8,349,003,311.56	7,593,635,632.35
1.2.2	Биет бус хөрөнгө	285,575,592.10	285,476,696.63
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,634,578,903.66	7,879,112,328.98
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,010,165,368.97	8,481,811,894.54
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	4,103,080.00	2,236,337.95
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татвар, НДШ-ийн өр	265,124,870.10	242,653,161.5
2.1.1.12			
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	269,227,950.10	244,889,499.45
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	269,227,950.10	244,889,499.45
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч:-төрийн		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	10,816,142,859.02	10,922,786,858.72
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(2,075,205,440.15)	(2,685,864,463.63)
2.3.11	Эздийн өмчийн дүн	8,740,937,418.87	8,236,922,395.09
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,010,165,368.97	8,481,811,894.54

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12 сарын 31	2023 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	765,233,821.87	708,958,474.54
2	Борлуулалтын өртөг	2,401,289.09	70,796,575.71
3	Нийт ашиг(алдагдал)	762,832,532.78	638,161,898.83
4	Татаас санхүүжилтийн орлого		419,076,763.64
5	Хүүгийн орлого		324,997.98
6	Ногдол ашгийн орлого		
7	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		103,388,100.00
8	Бусад орлого		20,000,000.00
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,213,001,793.66	1,762,687,959.22
11	Санхүүгийн зардал		
12	Бусад зардал		2,039,759.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	634,500.00	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(449,534,760.88)	(583,775,957.77)
19	Орлогын татварын зардал		3,559.15
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(449,534,760.88)	(583,779,516.92)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(449,534,760.88)	(583,779,516.92)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
23.3	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(449,534,760.88)	(583,779,516.92)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 03-р сарын 31-ний үлдэгдэл		8,130,662,473.02	(1,441,459,523.40)	6,689,202,949.62
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			(184,211,155.87)	(184,211,155.87)
3	Залруулсан үлдэгдэл		8,130,662,473.02	(1,625,670,679.27)	6,504,991,793.75
4	Тайлант үеийн цэвэр ашиг(алдагдал)			(449,534,760.88)	(449,534,760.88)
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
9	2022 оны 12 -р сарын 31-ний үлдэгдэл	-	10,816,142,859.02	(2,075,205,440.15)	8,740,937,418.87
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			26,879,506.58	26,879,506.58
11	Залруулсан үлдэгдэл	-			
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(583,779,516.92)	(583,779,516.92)
13	Бусад дэлгэрэнгүй орлого				-
14	Өмчид гарсан өөрчлөлт		106,643,999.70		106,643,999.70
15	Зарласан ногдол ашиг				-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн				-
17	2023 оны 12 -р сарын 31 -ний үлдэгдэл	-	10,922,786,858.72	(2,685,864,463.63)	8,236,922,395.09

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	916,193,878.78	1,283,249,677.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	570,113,878.78	835,249,677.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	346,080,000.00	448,000,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	964,514,287.25	1,247,278,955.24
1.2.1	Ажиллагчдад төлсөн	184,631,023.00	296,710,583.35
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	71,905,986.61	94,249,693.44
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	342,099,992.29	161,659,260.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	271,793,311.51	352,899,499.08
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	68,481,340.00	147,513,559.72
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	-	-
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	11,433,747.84	164,959,427.79
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		222,600.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	14,168,886.00	29,064,331.26
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(48,320,408.47)	35,970,721.76
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	3,383,597.98
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		3,058,600.00
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого		324,997.98
2.1.7	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	53,994,000.00	11,559,999.70
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	53,994,000.00	11,559,999.70
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(53,994,000.00)	(8,216,401.72)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(102,314,408.47)	27,754,320.04
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	109,025,949.99	6,711,541.52
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	6,711,541.52	34,465,861.56

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2022 оны гүйцэтгэл	2023 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Нийт орлогын дүн	765,868.3	1,103,761.1	1,251,748.3	147,987.2	113.4
1	Татаас санхүүжилтээс	346,080.0	450,000.0	450,000.0	-	100.0
2	ОУХТөв түрээсийн орлого	359,518.4	556,329.6	525,828.3	(30,501.3)	94.5
3	Нийтийн тээврийн орлого	2,639.8	3,519.7	3,282.7	(237.0)	93.3
4	Мал нядалгааны орлого	21,489.0	63,000.0	49,132.0	(13,868.0)	78.0
5	Сайнханы хөтөлийн орлого	19,314.9	19,315.0	39,705.1	20,390.1	205.6
6	Журмын хашааны түрээсийн орлого	7,540.8	11,596.8	11,535.4	(61.4)	99.5
7	Бусад орлого	9,285.5	-	172,264.8	172,264.8	
	Нийт зардлын дүн	1,215,403.1	1,077,440.5	1,835,524.2	758,083.8	170.4
1	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	156,462.5	407,205.9	363,511.2	(43,694.7)	89.3
2	Ажил олгогчоос НДШ	34,621.5	58,411.8	53,125.7	(5,286.1)	91.0
3	Бичиг хэрэг	2,965.8	3,259.8	3,179.0	(80.8)	97.5
4	Гэрэл цахилгаан	129,980.4	257,503.8	276,409.2	18,905.3	107.3
5	Түлш, халаалт	46,911.0	45,982.6	63,111.8	17,129.2	137.3
6	Тээвэр (шатахуун)	50,810.6	68,910.8	66,207.9	(2,702.9)	96.1
7	Шуудан, холбоо, интернет	112.0	4,272.0	4,680.0	408.0	109.6
8	Ариутгал, Цэвэрлэгээ	11,188.6	5,571.6	6,699.9	1,128.3	120.3
9	Цэвэр, бохир ус	15,818.2	20,568.1	33,378.5	12,810.4	162.3
10	Дотоод албан томилолт	215.0	456.0	3,059.7	2,603.7	671.0
11	аудитын төлбөр	2,000.0			-	
12	Маягт үнэт цаас хэвлүүлэх зардал	2,565.1	2,500.0	2,400.0	(100.0)	96.0
13	Гэрэлтүүлгийн сэлбэг хэрэгсэл		19,578.9	50,056.3	30,477.4	255.7
14	Тээврийн хэрэгслийн сэлбэг хэрэгсэл		16,962.4	16,465.8	(496.6)	97.1
15	Тээврийн хэрэгслийн оношлогоо	231.0			-	
16	Тээврийн хэрэгслийн татвар	6.3			-	
17	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,710.0	-	-	-	
18	Урсгал засвар	123,168.5	19,500.0	22,000.0	2,500.0	112.8
19	Гэрэлтүүлгийн засвар үйлчилгээ		18,000.0	18,000.0	-	100.0
20	Жижиг эд хогшил	4,000.0	-	-	-	
21	Төлбөр хураамж болон бусад зардал	19,033.4	172.0	303.0	131.0	176.2
22	Үл хөдлөх хөрөнгийн татвар	17,545.1	17,545.1	17,545.1	0.0	100.0
23	банкны шимтгэл	136.2			-	
24	Ахмад настангуудад		1,000.0	900.0	(100.0)	90.0
25	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал	500.0	11,000.0	9,902.4	(1,097.6)	90.0
26	Элэгдлийн зардал	506,485.4		705,633.0	705,633.0	
27	ББӨ	2,401.3	99,039.7	118,955.7	19,916.0	120.1
	Ашиг алдагдал	(449,534.8)	26,320.6	(583,776.0)	(610,096.5)	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь “Сүхбаатар сумын ард иргэдийг тэгш хүртээмжтэй, соёлч боловсон, түргэн шуурхай үйлчилгээгээр ханган ажиллах” гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Худалдааны төвийн тохижилт, орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх, хяналт тавих, батлагдсан төлөвлөгөөний хүрээнд зарцуулалт хийх, үр ашигтай ажиллуулах,
- Худалдааны төвд үйл ажиллагаа явуулах иргэн, байгууллагатай гэрээ хийх, байр талбайг ашиглуулах, ашиглалтын төлбөр тооцоог хийх,
- Орон нутгийн өмчийн тээврийн хэрэгслээр аймгийн төвд эрх бүхий байгууллагын тогтоосон чиглэл, хуваарь, үнэ тарифаар нийтийн зорчигч тээврийн үйлчилгээ эрхлэх, төсвийн байгууллагад захиалгат үйлчилгээг тогтоосон үнэ тарифаар үзүүлэх,
- Орон нутгийн өмчийн мал нядалгааны цэг, махны хөргүүрт зоорины ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх,
- Эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрийн дагуу аймгийн махны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, түгээх ажил үйлчилгээг эрхлэх,
- Сүхбаатар сумын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, түүний засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Тус үйлдвэрийн газрын үүсгэн байгуулагч нь Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал, төлөөлөн хэрэгжүүлэгч нь сумын Засаг дарга байх бөгөөд 100.0 хувь орон нутгийн өмчтэй аж ахуйн нэгж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ыг сумын ИТХ-ын 2022 оны 38 дугаар тогтоолоор байгуулсан байна. Энэ нь Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлд “Сум, дүүргийн Хурлын бүрэн эрх”, 18 дугаар зүйлийн 18.1.3 ж-д “Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргах, **дүрмийг батлах**”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2-д “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараах бүрэн эрхтэй:... 4/ **орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих**” гэсэн заалттай нийцэж байна.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль Нийгмийн даатгалын багц хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон

нутгийн өмчийн тухай хууль, ТБОНӨХБАҮХА тухай хууль зэрэг хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон гэх мэт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул байна гэж үзлээ.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын үйл ажиллагаанд Сүхбаатар сумын ИТХ, ЗДТГ, төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Тус газрын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч борлуулалтын орлого, өртгийн тооцоолол, хөрөнгө оруулалтын талаар нарийн тусгаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид

мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 528,353.5 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,711.6	34,465.9	27,754.3
Авлага	88,617.9	118,335.3	29,717.4
Бараа материал	280,256.9	449,898.3	169,641.4
Үндсэн хөрөнгө	8,634,578.9	7,879,112.3	(755,466.5)
Нийт хөрөнгө	9,010,165.3	8,481,811.8	(528,353.5)
Өр төлбөр	269,227.9	244,889.5	(24,338.4)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	8,740,937.4	8,236,922.4	(504,015.0)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	9,010,165.37	8,481,811.8	(528,353.5)

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данснууд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 34,465.9 мянган төгрөг болж, 27,754.3 мянган төгрөгөөр өссөн нь касс болон харилцах дансаар 1,282,937.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,255,183.3 мянган төгрөг зарцуулснаас шалтгаалжээ.
- Авлага дансны үлдэгдэл 118,335.3 мянган төгрөг болж 29,717.4 мянган төгрөгөөр өссөн нь нөөцийн махны авлага өссөнөөс голлон шалтгаалсан байна. Нийт авлагын 47.4 хувь буюу 56,010.5 мянган төгрөгийг нөөцийн махны авлага, 37.4 хувь буюу 44,299.2 мянган төгрөгийг түрээсийн авлага, 15.2 хувь буюу 18,025.6 мянган төгрөгийг байгууллага, хувь хүнээс авах авлага эзэлж байна. Авлагын үлдэгдэлд хугацаа хэтэрсэн, эзэн холбогдогч тодорхойгүй, насжилт өндөртэй түрээсийн 29,548.8 мянган төгрөгийн найдваргүй авлага байна.
- Бараа материал дансны үлдэгдэл 449,898.3 мянган төгрөг болж 169,641.4 мянган төгрөгөөр өссөн нь Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 515 дугаар албан бичгээр 25 төрлийн 176,931.1 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлсэн, үнэ төлбөргүй 8,388.1 мянган төгрөгийн материал шилжиж ирснээс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 7,878,781.1 мянган төгрөг болж 755,797.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд 705,633.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулснаас голлон шалтгаалсан байна. Үндсэн хөрөнгө дансанд дараах өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 2023 оны 515 дугаар албан бичгээр 25 төрлийн 176,931.1 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд шилжүүлсэн,
- Аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар тогтоолоор 36,880.0 мянган төгрөгийн өртөгтэй 11,627.6 мянган төгрөгийн элэгдэлтэй 3 машин, 18,156.8 мянган төгрөгийн өртөгтэй, 9,173.9 мянган төгрөгийн элэгдэлтэй 15 төрлийн тоног төхөөрөмж, 252.0 мянган төгрөгийн өртөгтэй, 31.5 мянган төгрөгийн элэгдэлтэй 4 ширхэг тавилгыг данснаас хассан.
- Сэлэнгэ аймгийн ОНӨГ-ын 200 дугаар албан бичгээр сумын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдсэн 95,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий дунд оврын автобусыг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, 8,000.0 мянган төгрөгийн хөргүүрийн тоног төхөөрөмж, 3,644.0 мянган төгрөгийн компьютер худалдан авсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 244,889.5 мянган төгрөг болж, 24,338.4 мянган төгрөгөөр буурсан нь татварын өрийг төлсөнтэй холбоотой байна

3.5 Техник, эдийн засгийн зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу "Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ААТҮГ-ын дарга нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

"Өргөн Сэлэнгэ үйлчилгээ" ААТҮГ-ын 2023 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулж, тайлант оны нийт орлогыг 1,103,761.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 1,077,440.5 мянган төгрөгөөр, 26,320.6 мянган төгрөгийн ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 1,251,748.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 1,835,524.3 мянган төгрөгийн зардал гарган, 583,776.0 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлого:

- ОУХТөв түрээсийн орлого 525,828.3 мянган төгрөг,
- Нийтийн тээврийн орлого 3,282.7 мянган төгрөг,
- Мал нядалгааны орлого 49,132.0 мянган төгрөг,
- Сайханы хөтлийн орлого 39,705.1 мянган төгрөг,
- Журмын хашааны түрээсийн орлого 11,535.1 мянган төгрөг,
- Бусад орлого 172,264.8 мянган төгрөг,
- Татаас санхүүжилт 450,000.0 мянган төгрөг зэрэг.

Нийт орлогын гүйцэтгэл 1,251,748.3 мянган төгрөг болж төлөвлөснөөс 147,987.2 мянган төгрөгөөр буюу 13.4 хувиар давж биелэсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 1,835,524.3 мянган төгрөг болж, төлөвлөснөөс 758,083.8 мянган төгрөг буюу 70.4 хувиар хэтэрсэн нь элэгдлийн зардлыг зардлын төлөвлөгөөнд нэмж тусгаагүйгээс шалтгаалсан байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот тувшний төлөвлөгөө, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт, орлого, зардлын зүйлс тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд “Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-ийн аудитор О.Чулуунбаатар, анхан шатны хяналтыг захирал О.Бурмаа гүйцэтгэж, дараагийн шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайлангаа Аав ээжийн тэнгэрлэг буян аудит ХХК-д 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 1,215,403.1 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 12,154.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.3.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор

www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн системд 27 төрлийн 170 мэдээлэл байршуулахаас 20 төрлийн 143 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 3 төрлийн мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож, 3 төрлийн мэдээллийг огт мэдээлээгүй байна. Үүнд:

Хугацаа хоцроосон мэдээллүүд:

- Төрийн өмчийн аж ахуйн нэгж байгууллагын зорилтот түвшин, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарын хамт- 4 удаа
- Дараа жилийн зорилтот түвшин
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан,

Огт мэдээлээгүй мэдээлэл: ,

- Худалдан авах ажиллагааны тайлан,
- Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр,
- Их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээлэл.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь “*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*” гэсэн заалт болон 6 дугаар зүйлийг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.3.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд шатахуун худалдан авах 68,910.0 мянган төгрөгийн худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна.

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтад “Магнай трэйд” ХХК шалгаран, гэрээ байгуулан худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн тус байгууллагын худалдан авах ажиллагаа нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн холбогдох заалттай нийцсэн байна.

4.4 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй ,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан гэх мэт.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,870.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 2 албан шаардлага, 1 хариуцлага тооцуулах албан шаардлага, 2 зөвлөмж өгснийг нотлох баримттай тулган шалгахад 66.7 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 2. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	2,870.0	1	2,870.0	100
Албан шаардлага	2	66,093.4	2	66,093.4	100
Хариуцлага тооцуулах албан шаардлага	1		1		100
Зөвлөмж	2	15,590.8			
Нийт дүн	6	84,554.2	4	68,963.4	66.7

Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэж, ажил гүйлгээг гүйцэтгэж байх, шилэн дансны мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дараагийн аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

- Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгийн тооллого хийж, биет тест хэрэгжүүлэх горимыг бүрэн хэрэгжүүлээгүй учир дараагийн аудитаар тулган шалгах нь зүйтэй юм.
- Тус ААТҮГ нь үйлдвэрлэлийн үр дүнгээр алдагдал хүлээж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байгаа нь удирдлага, менежментийн үйл ажиллагаатай холбоотой эсэх, шаардлагатай бол бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх эсэхийг гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах нь зүйтэй юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулга

Аудитаар нийт **198,718.4** мянган төгрөгийн нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 5 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

Залруулсан алдаа:

- Татварын тайланд борлуулалтын орлогыг 115,009.7 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан,
- Тэтгэвэрт гарсан албан хаагчид олгосон 1 удаагийн тэтгэмжээс 950.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж авсныг татварын тайланд тооцоо үүсгүүлж, хувь хүнд төлөх өглөгөөр бүртгүүлсэн,
- Худалдан авалтын НӨАТ-ын татварын 58,770.9 мянган төгрөгийн дүнг өглөг данс руу хаагаагүй.
- Үндсэн хөрөнгөөс бараа материал руу шилжүүлсэн 23,656.5 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг буруу дансанд хаасан.
- Үндсэн хөрөнгийг НӨАТ-гүй үнээр орлогодсон 331.1 мянган төгрөг зэрэг.

Аудитаар нийт **191,535.3** мянган төгрөгийн зөрчил илэрч, **18,622.7** мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй ажиллах **143,363.8** мянган төгрөгийн 3 албан шаардлага, **29,548,8** мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Төлбөрийн акт

1. Өдөр тутмын үйл ажиллагааг удирдах, төлбөр тооцоог хянах үйл ажиллагаа хангалтгүйгээс тайлант онд шинээр бэлтгэсэн махны борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлэлгүйгээр 21 аж ахуйн нэгж, хувь хүмүүсээс авах **18,622.7** мянган төгрөгийн авлага шинээр үүсгэсэн нь насжилт өндөртэй нөөцийн махны авлагыг нэмэгдүүлэх эрсдэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх "Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...." гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Шийдвэрлэсэн нь: Шинээр үүссэн махны борлуулалтын авлагыг барагдуулж, төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд **37,934.9** мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна. Энэ нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь *“зардал бодитой гарсан бөгөөд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан баримт болон холбогдох бүртгэлээр баталгаажсан байх”*, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь *“Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1 дэх *“Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана.”*, 4.2.1.10: *“Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол”* гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Боловсруулж, батлуулсан 2023 оны санхүүгийн төлөвлөгөөнд тусгагдсан зардлын төлөвлөгөөг **52,450.8** мянган төгрөгөөр / зардлын төлөвлөгөөнд тусгаагүй үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг хасч тооцсон / хэтрүүлсэн байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.3 дахь *“Үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах”* гэсэн заалт болон сумын Засаг даргын баталсан 2023 оны *“Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг”*-г зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Үйлдвэрлэлийн удирдлага, менежментийг сайжруулах, “Үйлдвэрлэл санхүүгийн төлөвлөгөө”-г бодитоор төлөвлөх замаар батлагдсан зардлын төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

3. Махны нөөц үүсгэх зориулалтаар өмнөх онуудад аймгийн төсвийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн нөөцийн махны борлуулалтын **52,978.1** мянган төгрөгийг татварын өрөнд суутгуулснаас 2023 онд махны нөөц бүрдүүлээгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх *“Захирал дараах эрх үүрэгтэй”*, 20.1.2: *“Үйлдвэрийн газрын нэрийн өмнөөс эд хөрөнгийг энэ хууль, гэрээнд заасан эрх хэмжээний дотод захиран зарцуулах”* гэсэн заалт болон тус үйлдвэрийн газрын дүрэмд заасан *“Эрх бүхий байгууллага албан тушаалтны шийдвэрийн дагуу аймгийн махны нөөцийг бүрдүүлэх,*

хадгалах, түгээх ажил үйлчилгээг эрхлэх” гэсэн үйл ажиллагааны чиглэлийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Татварын байгууллагатай тооцоо нийлж, махны нөөц бүрдүүлэх зориулалтаар төсвөөс санхүүжүүлсэн эх үүсвэрийг 2024 оны татвараас суутган тооцож, жилийн эцэст аймгийн махны нөөц бүрдүүлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3. Зөвлөмж

1. Орлого тогтоолт, орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал:

1.1 Илрүүлсэн нь: Халаалт дулаан, гэрэл цахилгаан, хэрэглээний ус зэрэг байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд 2023 онд 7,3-62.3 хувиар нэмэгдсэн нөхцөлд тус үйлдвэрийн газрын эзэмшилд бүртгэлтэй бөгөөд нийт орлогын 40.0 гаруй хувийг бүрдүүлж буй “Олон улсын худалдааны төв” -ийн 1м2 лангууны сарын түрээсийн төлбөрийг аймгийн ИТХ-ын 2017 оны 23 дугаар тогтоолоор өвлийн улиралд 23.7 мянган төгрөгөөр, зуны улирлыг 12.5 мянган төгрөгөөр тогтоон, өнөөг хүртэл мөрдөн ажиллаж байгаа нь үйл ажиллагааны үр дүнгээр алдагдал хүлээж, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байх 1 нөхцөл болж байна.

Өөрөө өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж чадахгүй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь “*Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж, бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ*” гэсэн заалт, тодорхойлолтыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын нэмэгдэл, зах зээлийн үнэ ханштай уялдуулан лангууны түрээсийн үнэ ханшийг тогтоох асуудлыг тооцоо, судалгаан дээр үндэслэн холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх, өөрөө өөрийгөө санхүүжүүлэн алдагдалгүй ажиллах нөхцөл боломжийг судалж, хэрэгжүүлэх.

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлсэн нь: Харилцагч нь тодорхой бус, насжилт өндөртэй **29,548.8** мянган төгрөгийн авлагад дүн шинжилгээ хийж, барагдуулах арга хэмжээ аваагүй, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах талаар арга хэмжээ аваагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх “*Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын Захирал удирдана*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Дээрх авлагуудад дүн шинжилгээ хийж барагдуулах, шаардлагатай бол холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж данс бүртгэлээс хасах арга хэмжээ авах.

3. Анхан шатны баримттай холбоотой асуудал

3.1 Илрүүлсэн нь: Авто машины улсын бүртгэлийн дугаар, спидометрийн заалт, шатахууны норм, явсан км зэрэг холбогдох бүртгэлүүд бичигдээгүй жолоочийн тооцооны хуудсаар буюу анхан шатны бүрдэл дутуу баримтаар шатахуун зарцуулалтын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*”, 13.7 дахь “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*” гэсэн заалтууд болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “*Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар*”-ын 3.3, 3.6, 6.4 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Холбогдох албан тушаалтнуудын гарын үсгээр баталгаажуулсан анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсний үндсэн дээр ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэл тайланд тусгаж байх.

4. Цалингийн тооцоолол, олголттой холбоотой асуудал

4.1 Илрүүлсэн нь: Ажилтнуудын цалинг сар бүр тогтоосон хугацаанд бус хүсэлт гаргасан тухай бүр олгож байгаа нь мөнгөн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сулруулж, цалин илүү, дутуу тооцогдох эрсдэлийг үүсгэж байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 104 дүгээр зүйлийн 104.1 дэх “*Цалин хөлсийг сард хоёроос доошгүй удаа **тогтсон өдөр** олгох бөгөөд олгох өдрийг хөдөлмөрийн дотоод хэм хэмжээ, эсвэл хөдөлмөрийн гэрээнд тусгана*” гэсэн заалтыг зөрчиж байна.

4.2 Өгсөн зөвлөмж: Цалин олгох тогтсон өдрийг хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн гэрээнд тусгаж, хэрэгжүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Татварын тайланд борлуулалтын орлогыг дутуу тайлагнасан	1	115,009.7	1	115,009.7			1	115,009.7				
1 удаагийн тэтгэмжээс ХХОАТ суутгасныг хувь хүнд өгөх өглөгөөр бүртгүүлсэн	1	950.0			1	950.0		950.0				
Худалдан авалтын НӨАТ-ын татварын дүнг өглөг данс руу хаагаагүй	1	58,770.9			1	58,770.9		58,770.9				
Үндсэн хөрөнгөөс бараа материал руу шилжүүлсэн элэгдлийн зардал	1	23,656.5			1	23,656.5		23,656.5				
Үндсэн хөрөнгөнд НӨАТ-гүй үнээр орлогодсон	1	331.3			1	331.3		331.3				
Дүн	5	198,718.4	1	115,009.7	4	83,708.7	5	198,718.4				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нөөцийн махны авлагыг барагдуулах	1	18,622.7	1	18,622.7								
Худалдан авалтыг төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй	1	37,934.9			1	37,934.9						
Баталсан зардлын төлөвлөгөөг хэтрүүлсэн	1	52,450.8			1	52,450.8						
Төсвийн санхүүжилтийг татварын өрөнд суутгуулж, махны нөөц бүрдүүлээгүй	1	52,978.1			1	52,978.1						

“Өргөн Сэлэнгэ үйлчилгээ” ААТҮГ-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Найдваргүй авлагыг шийдвэрлэх арга хэмжээ аваагүй.	1	29,548.8				1	29,548.8		
Бүрдэл дутуу анхан шатны баримтаар шатахууны зардлын гүйлгээг гүйцэтгэж, бүртгэлд тусгасан	1	-				1	-		
Лангууны түрээсийн үнийг бодитоор тогтоогоогүй	1					1			
Цалинг тогтмол хугацаанд олгоогүй	1					1			
Дүн	8	191,535.3	1	18,622.7	3	143,363.8	4	29,548.8	

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага				
			Тоо	Дүн	Тоо	Дүн			
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансанд 3 төрлийн мэдээллийг 6 удаа хугацаа хоцроож, 3 мэдээллийг огт оруулаагүй	1	-			1				-
Дүн	1	-			1				-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1	-			1				-